



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот


Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай” 11/34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 24.1.15 дахь заалтын 12 дахь хэсэгт “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18, 20 дугаар хороо)” гэснийг “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн Цэргийн хотхон орчим ХЕТ-2013-8 багцын “А” хэсэгчилсэн талбай болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18, 20 дугаар хороо)” гэж өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

111010004